



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 8 сарын 25 өдөр

Дугаар 327

Улаанбаатар хот

Г

Эрх шилжүүлэн
ажил гүйцэтгүүлэх тухай

Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 311 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XYI.1.2.1 Харьяа газрын засвар /улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний XYI.1.2.1.7 Гэнэтийн хүчин зүйлийн дагуу хийгдэх их засварын ажил /Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дотор халаалт, халуун хүйтэн усны систем болон гадна дулаан, цэвэр усны шугамын засварын ажилд 50,000,000 /Тавин сая/ төгрөг, эмнэлгийн хийн системийн угсралтын ажилд 50,000,000 /Тавин сая/, нийт 100,000,000 /Нэг зуун сая/ төгрөг/-ын гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх эрхийг Гэмтэл согог судлалын үндэсний төв /З.Мэндсайхан/-д шилжүүлсүгэй.

2. XYI.1.2.4 Аймаг, сумын эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар /улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний XYI.1.2.4.4 Улсын гуравдугаар төв эмнэлгийн дээврийн засварын ажил /Төсөвт өртөг 350,000,000 /Гурван зуун тавин сая/ төгрөг, үүнээс 2015 онд санхүүжих 250,000,000 /Хоёр зуун тавин сая/ төгрөг/-ын шууд гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх эрхийг Улсын гуравдугаар төв эмнэлэг /Ц.Төмөр-Очир/-т шилжүүлсүгэй.

3. Эрх шилжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 128 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081151